

## УЛС ТӨРИЙН НАМЫН ИНСТИТУЦЖИЛТ: ОНОЛЫН АСУУДАЛД

С.МӨНХБАТ

МУИС. Улс төр судлалын тэнхимийн  
эрхлэгч, доктор, профессор

Түлхүүр үг: Улс төрийн намын бүтэц, зохион байгуулалт, намын институцжилт, институцийн онол

\* \* \*

Улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын онцлог нь намын институцжих үйл явцын шинж байдлаас хамаарч байдаг. Тиймээс намын бүтэц зохион байгуулалтын асуудлыг авч үзэх үндэс нь намын институцжих үйл явцын тухай асуудлыг шинжилж үзэх явдал мөн. Нийгмийн бүлэг, байгууллага өөрсдийн үйл ажиллагааг тодорхой бүтэц, зохион байгуулалтад оруулснаар тавьсан зорилго, эрмэлзлэлдээ хүрэх бололцоо бий болдог. Намын бүтэц, зохион байгуулалтад орох үйл явц нь үзэл баримтлал, үйл ажиллагааны хүрээнд институцжих үйл явцаас эхэлдэг.

Институцжих буюу Англиар Institutionalization гэдэг үгийг Англи-Монгол толь бичигт 1. Үүсгэн байгуулах, 2. Албан ёсны болгох, албан ёсны болж тогтох<sup>1</sup> гэж орчуулсан байна. Судлаач А. Панебианко намын институцжих үйл явцыг “намын зорилго болон үнэлэмжүүд тодорхой үндэслэгээгээр нэгтгэгдэж байгаа үйл явц юм”<sup>2</sup> гэж үзсэн бол судлаач Ф. Селзник “намын институцжилт гэдэг нь нам зохион байгуулалтын зайлшгүй байдлаа ухаарч түүнийг бодит зорилгод нийцүүлэн институциональ үйл ажиллагаа, функциональ бүтэц бий болгоход чиглэсэн түрэлт бүхий үйл явц юм”<sup>3</sup> гэж тодорхойлсон байна.

Ямарваа нэг намыг үүсгэн байгуулагчдын гол зорилго бол зохион байгуулалтын зайлшгүй байдлыг ухаарч, нэг талаас зохион байгуулалтыг биежүүлж хэв маягт оруулах, нөгөө талаас институцжих үйл явцыг түүний “ухаанжсан” зорилгууд болгоход анхаарах ёстой байдаг байна. Энэхүү зайлшгүй хоёр тал нь тухайн намын бүтцийн суурь үндэс болсноор институцжих үйл явц эхэлдэг.

Судлаач Ф.Селзникийн үзэж байгаагаар сонирхлуудын институцжилт нь зохион байгуулалтыг хадгалах үйл явцтай шууд холбогддог нь (зохион байгуулалтын пирамидын ялгаатай түвшнүүд дэхь лидерүүдийн байр, суурь, сонирхол) нам дахь шатлал бүхий бүтэц хэвшин тогтох үндэс болж намын байгуулалт дахь зөв, шударга байдлын тархалтын хөгжилт болж хувирдаг<sup>4</sup> байна.

Хэрэв институцжих үйл явцад сонирхлын хүчин зүйл давамгайлах хандлагтай бол *сонголтын*, зөв, шударга, тэгш байдлын хүчин зүйл давамгайлах хандлагтай бол *нэгдлийн* хүчин зүйлийн нөлөө их байдаг байна. Эндээс үзвэл намын институцжилт нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий цогц, нарийн үйл явцаар дамжин хэрэгждэг байна. Аливаа нэг байгууллага тухайлбал нам түүний институцжих үйл явц дахь зохион байгуулалт тогтвортой байж чадвал “хүчтэй” бүтцийг, харин тогтворгүй, тохиолдлын шинжтэй байвал “сул” бүтцийг бий болгох хандлагтай байдаг аж. Судлаач А.Панебианко энэ хандлагыг улс төрийн намын хүрээнд нарийвчлан судлаад “Намын институцжих үйл явц тасралтгүй үргэлжилж тодорхой бүтцийг бий болгох нь үүслийн зөв загварууд дээр үндэслэгдсэн намын хэв маягийг хөгжүүлэх боломжийг нээж өгдөг”<sup>5</sup> гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ нь улс төрийн намын институцжилтийн ерөнхий хандлагыг илтгэх “үзүүлэлт” бөгөөд намуудын хувьд энэ үйл явцын эхлэх гарааны нөхцөл нь ижил байдаг байна. Харин хөгжлийн явцад институцжих үйл явц харилцан ялгаатай бүтцүүдийг бий болгодог нь ажиглагддаг. Ингэхдээ энэ нь хоёр үндсэн хэмжээсээр хэмжигдэнэ. Үүнд:

1. Бүтэц зохион байгуулалтын хэмжээ, эх үндэс нь хүрээлэн буй орчноос хараат бус бие даасан байх.
2. Бүтэц зохион байгуулалтын ялгаа бүхий дотоод хэсгүүдийн бие даасан байдал, харилцан уялдаа холбоо зэрэг болно. Нам нь гадаад орчинтойгоо байнгын харилцаанд оршиж нийгэм, улс төрийн системтэйгээ солилцоо явуулж хүрээгээ тэлэн нөөцөө сэлбэж байдаг. Учир нь намд зөвхөн гишүүдээ

<sup>1</sup> Oxford English Mongolian Dictionary. УБ., 2006

<sup>2</sup> Angelo Panebianco. Political parties: organization and Power. Cambridge., 1988.p.53

<sup>3</sup> Philip Selznick. Leadership in Administration. London.,1986.p.93

<sup>4</sup> S.N.Eisenstadt. Social Differentiation and Stratification. Scotland.1965.p.39

<sup>5</sup> Angelo Panebianco. Political parties: organization and Power. Cambridge., 1988.p.55

төдийгүй нийт нийгмийн хүрээнд хүрч ажиллах зайлшгүй шаардлага байнга тулгардаг. Энэхүү шаардлагуудыг хангах, нийгэмд легитимээ бий болгохын тулд нам зайлшгүй институцжсэн байх ёстой. Энэ утгаар авч үзэх юм бол нам институтжилтийн үр дүнд гарч ирсэн бүтэц, нэгдэл мөн. Тиймээс энэхүү өгүүллийн гол зорилго нь намын институцжилтийн хэм хэмжээг гаргах, энэ хэм хэмжээ намын хэв маягууд, түүний үүслийн загваруудад хэрхэн хамааралтай болохыг тодруулахад чиглэгдэнэ.

Намын институцжилтэд нийгмийн орчноос хараат бус байх шинж чухал байдаг. Намын институцжилтийн ялгаатай байдлын гадаад илрэл нь өөр хоорондоо ялгаа бүхий улс төрийн намуудын хэв маяг юм. Сайн зохион байгуулагдсан нам л нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж чаддаг. Үүний тодорхой жишээ бол олон түмний нам бөгөөд М.Дюверже энэ намын хэв маягийг нийгмийн орчиндоо тусгаар байх чадвар бүхий маш сайн институцжсэн байгууллага гэж дүгнэсэн<sup>6</sup> юм. Олон түмний нам нь санхүүгийн нөөцөө шууд хянадаг нийгмийн олон хэв маяг бүхий бүлэг, давхраануудад төвлөрөн бэхжиж тэр нь захиргааны аппаратад нь нэгтгэгддэг. Түүнчлэн намын удирдагч, лидерүүдийнх нь үйл ажиллагааг төлөөлөгчдийн хурал хянадаг намын бүтэц, зохион байгуулалт нь маш сайн институцжиж бэхжсэн байдаг<sup>7</sup> байна.

Намын институцжилтийн өөр нэг шинж бол намын бүтэц зохион байгуулалтын уялдаа холбоогоор илэрхийлэгддэг. Энэ нь намын бүтэц зохион байгуулалтын дотоод дэд системүүдийн хоорондын уялдаа холбоо, тэдгээрийн эрэмбэлэгдсэн байдлын түвшин юм. Учир нь “зохион байгуулагдсан системлэг бүтэцэд түүний дотоод дэд системүүдийн хооронд бие биеэсээ хамаарсан маш олон тооны харилцаа үүсдэг байна”<sup>8</sup>. Энэхүү харилцааны системчлэгдсэн байдал нь зохион байгуулалтын олон төрлийг бий болгодог. Учир нь системийн дотоод дахь элементүүдийг тэтгэж байдаг гадаад эх үүсвэрүүд нь өөр хоорондоо ялгаатай учир түүгээр нөхцөлдөн бий болсон дэд системүүд нь өөр хоорондоо ялгаатай байдаг аж. Ийм тохиолдолд намын бүтэц зохион байгуулалтын нэг орчноос хамаарах шинжийг багасгадаг сайн талтай ч, төвөөс хамаарах дэд системүүдийн бие даасан байдлыг улам нэмэгдүүлж нам дахь сонирхлуудыг идэвхжүүлдэг сул тал бас бий. Эндээс л нам дахь бүлгүүдийн сонирхол институцжих үйл явц эхэлж жигүүр, фракцууд үүсэх нөхцөл бүрддэг байна.

Хэрэв намын институцжилт сул байвал намын бүтэцэд хамаарч буй дэд хэсгүүдийн төвөөс хамаарах хамаарал багасаж бие даах шинж нь улам бүр нэмэгддэг байна. Харин институцжилт сайн байвал намын бүтэц дэхь дэд хэсгүүдэд хүрээлэн буй орчинтой хийх нөөцийн солилцоог хянах, төвлөрсөн тогтолцоо бий болгох бололцоог бүрдүүлж өгдөг байна. Өөрөөр хэлбэл намын бүтцийн институцжсэн байдал нь намын хүрээлэн буй орчинтой харилцах харилцааг улам бүр нягт болгох боломжийг өсгөдөг гэсэн үг юм. Харин намын бүтцийн институцжилтийн сул байдал нь хүрээлэн буй орчны ялгаатай элементүүдээс нөөцөө бүрдүүлж, тэр хэмжээгээрээ нам дотор өөр өөр эх үүсвэр бүхий бие биенээсээ ялгаатай дэд бүлгүүдийг бий болгоход хүргэдэг байна.


Диаграмм 1.

Автономит байдал

Хүчтэй институцжилт

Сул институцжилт

Сул системчлэл



Намын институцжих үйл явц нь эцсийн дүндээ зохион байгуулалтын зайлшгүй байдалтай холбоотой гэдгийг өмнө дурьдсан. Нам судлалд намын зохион байгуулалтын зайлшгүй байдлыг дараах 3 альтернатив загвараар тодорхойлсон байдаг. Үүнд:

*Зохистой, оновчтой бүтцийн эсрэг байгалийн системийн загвар.* Энэ загвар нь намын бүтэц зохион байгуулалтын шинжийг тодорхойлох сонгодог альтернатив загвар юм. Бүтэц оновчтой байвал зохион байгуулалт нь тодорхой зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болдог. Өөрөөр хэлбэл аливаа зохион байгуулалтын дотоод эмх цэгц бол тухайн байгууллагын зорилгодоо хүрэх чиглүүлэгч нь болдог юм.

<sup>6</sup> Дюверже.М. Политический партии. М., 2000.с. 47

<sup>7</sup> Дюверже.М. Политический партии. М., 2000.с.47-54

<sup>8</sup> A. VanDoom. Conflict in formal Organizations, in A. Renck. Conflict in Society. Boston. Little Brown and Co., 1966. p. 1

Гэхдээ ямар ч хэлбэржсэн бүтэц бодит зорилгуудаа энэ тэргүүнд ил гаргаж тавьдаггүй. Тухайлбал: Фирмийн гол зорилго нь эн тэргүүнд их хэмжээний ашиг олох явдал биш байж болох юм. Фирмийн үйл ажиллагаа нь өөр бусад зорилго, зорилтуудад захирагдмал байдагтай, тухайлбал фирмийн гадаад, дотоод бүрэн эрхт, бие даасан, тогтвортой байдлыг хадгалах, зах зээл дээр өөрийн нэр хүндийг өсгөх зэрэгтэй дам холбоотой байж болно.

Уламжлалт оновчтой бүтцийн загваруудын үндэс нь өөр хоорондоо ялгаатай бөгөөд тухайлбал, системийн хандлагаар зохион байгуулалт алсдаа заавал биелүүлэх зорилгуудын бодит байдал болон төлөвшсөн байх албагүй. Зарим тохиолдолд тодорхой зорилтуудыг хэрэгжүүлээд өөрөө үгүй болдог бүтцүүд гэж бий. Ийм байдлын тодорхой илрэл бол улс төрийн хөдөлгөөнүүд юм. Энэ нь улс төрийн системд байнга ажиглагдаж байдаг. Харин намын хувьд асуудал өөр юм. Учир нь ямарваа нам үйл ажиллагаа, үзэл баримтлал, үнэт зүйлсийнхээ хувьд нийгмийн өмнө үүрэг хүлээж нийгмийн зүгээс тэрхүү үүргүүдийг эрх зүй болон ёс зүйн хүрээнд хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байдаг.

Зохион байгуулалт, менежментийн үүрэг нь институцжих үйл явц, тэр дундаа ашиг сонирхлуудын хоорондын тэнцвэрийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг энэ загвар чухалчилдаг юм. *Зохион байгуулалт бол нэг талдаа зорилгод хүрэх, түүнийг хангах арга, нөгөө талдаа тодорхой зорилгоос үүдэн гарч ирсэн бүтэц юм.*

Р.Михельс намд зохион байгуулалтын дараах хоёр загвар байдаг хэмээн үзсэн байна. Үүнд, 1. Нам анх бий болохдоо түүнийг үүсгэн байгуулагчдын бодит зорилгын үндсэн дээр бий болдог. Энэ бол оновчтой системийн загварын дагуу бий болсон бүтэц юм. 2. Намын хөгжлийн явцад сонирхлын ялгаа бүхий хэсгүүд бий болж тэд өөрсдийгөө хамгаалах хандлага өсдөг. Энэ бол байгалийн системийн загварын дагуу бий болсон бүтэц юм гэжээ. Эндээс Р.Михельс “байгууллагын удирдлага нь үйл ажиллагаа тогтвортой үед байгууллагын гол зорилгыг биш байгууллага доторх өөрийн байр суурийг бэхжүүлэхийг эрмэлзэж байдаг”<sup>9</sup> гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Өөрөөр хэлбэл нам институцжин хөгжих эхлэл нь тодорхой зорилгын (засгийн эрх авах, түүнд нөлөөлөх г.м) үндсэн дээр нэгдэлд суурилсан зарчмын дагуу зохион байгуулагдаж, хөгжлийн дараагийн шатанд ялгаа бүхий сонирхлууд гарч ирсэнээр намд сонголтын хүчин зүйл давамгайлах хандлагатай болж хөгждөг байна.

*Нэгдлийн эсрэг сонголтын хүчин зүйлсийн загвар.* Энэ загвар хоёр үндсэн зарчимд суурилдаг юм. Үүнийг судлаач Ж.Вильсон дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд, 1. Нам тодорхой дэг жаягийн дагуу зохион байгуулагдаж түүний бүтцэд нэгдлийн хүчин зүйлс зайлшгүй шаардлагатай гэдгийг оролцогчдод итгэл, үнэмшил болгосон байх 2. Харин зохион байгуулалтын үндэс нь сонголтын хүчин зүйлсүүдэд суурилдаг ба ач холбогдол нь зөвхөн зарим оролцогчдын хувьд хувирамтгай, зөрөөтэй байдлаар тархсан байдаг<sup>10</sup> гэжээ.

Эндээс үзэхэд дээрх хоёр хувилбар нь намын бүтэц зохион байгуулалт нэгдлийн хийгээд сонголтын хүчин зүйлсээс хамаарч ялгаатай байдлаар бий болдог гэдгийг гаргахад ач холбогдолтой юм. Тухайлбал: нэгдлийн хүчин зүйлсийн онолоор бие хүний үнэт зүйлсүүд нийт нийгмийн шинж чанартайг онцолж нэг оролцогчийн үйл хэрэг нь цаад агуулгаараа нийгэм, улс төрийн зорилгоор нөхцөлдөг гэдгийг үндэслэгээ болгодог байна. Өөрөөр хэлбэл бие хүний асуудал нь макро түвшиндөө нийт нийгмийн асуудал болж тавигддагт хэргийн учир оршиж байгаа юм. Харин сонголтын хүчин зүйлсийн онолоор өөр үзүүлэлтүүдийг авч үздэг юм. Үүнд: засаглал руу тэмүүлэх тэмүүлэл, нийгмийн статусаа ахиулах эрмэлзлэл, материаллаг нөхцөлө сайжруулах гэх мэт. Учир нь нийгмийн хөгжлийн эх үндэс бол хүний хөгжлийг тал бүрээр хангах явдал бөгөөд ингэхийн тулд хүний сонголт хийх боломжийг өргөжүүлэх явдал чухал гэж үзнэ. Хэрэв намын бүтцэд сонголтын хүчин зүйлс тархмал байвал нам дотор нээлттэй бүтэц бий болж нэгдлийн хүчин зүйлсийн тархмал байдал хязгаарлагдаж ирдэг байна. Харин нэгдлийн хүчин хүчин зүйлс давамгайлах үед зохион байгуулалтын нээлттэй бүтэц бэхжих явдал харьцангуй багасдаг ажээ.

Бие хүний сэтгэл ханамжийн байдал нь сонголтууд тэдгээрийг хийх нөхцөл боломжоос хамаардаг бол харин зохион байгуулалтын төвлөрсөн шинж нь нэгдлийн хүчин зүйлсүүд байдаг тул чухамдаа сөрөг тэнцвэрийг бий болгодог. Иймд нам дахь нэгдлийн хүчин зүйлсүүд бодит байдал дээр хэдийгээр уялдаа хамааралтай мэт байдаг боловч мөн чанар нь албан ёсны сонирхлуудын илрэл юм.

Нам доторх сонирхлууд нь сонголтын хүчин зүйлсүүдийг урьтал болгоход чиглэх бөгөөд зохион байгуулалтын шинжийг байгалийн системийн загвар руу оруулж, институцжих үйл явцыг олон янзын эрэлт хэрэгцээнүүдийг тэнцвэржүүлж тэнцвэрийг хангах байдлаар төлөвшүүлэхийг шаарддаг. Харин намын бүтцийн төвлөрсөн шинж нь нэгдлийн хүчин зүйлсүүдийг төрүүлэхэд хүргэдэг бөгөөд зохион байгуулалтын оновчтой системийн загварыг бий болгоход чиглэдэг байна. Энд ялангуяа үзэл суртлын үүрэг их. Тухайлбал намын зохион байгуулалт дахь сонголтын хүчин зүйлс мэдэгдэхүйц илт давамгайлах үед намын төвлөрсөн

<sup>9</sup> Angelo Panebianco. Political parties: organization and Power. Cambridge., 1988.p.7

<sup>10</sup> J.Q. Wilson. Political Organizations. New York. Basic Books. 1973.p.70

бүтэц эр зөөлөрч нэгдлийн хүчин зүйлсийг түгээгч механизм уян хатан болж ирдэг байна. Энэ байдал н тухайн намын хувьд бүтэц, зохион байгуулалтын нээлттэй, сул бүтцийг бий болгож төлөвшүүлэх үндэ болдог. Ийм бүтцийг төлөвшүүлсэн байдал Америк маягийн намын бүтцийн шинж байдлаас тод ажиглагда байдаг юм.

Хүснэгт 2

Намын бүтцийн төлөвшил, хөгжлийн үе шатууд<sup>11</sup>

д/д	Нэгдүгээр үе шат	Хоёрдугаар үе шат	Гуравдугаар үе шат
	Эв нэгдлийн систем		Сонирхлуудын систем
1	Оновчтой загвар: Гол зорилго бол нийтийн үйл хэргийг бодит байдал болгох	Institutionalization Институцжих үйл явц	Зүй ёсны /байгалийн/ системийн загвар: оролцогчдын сонирхолуудын эсрэг тэсрэг блансыг тэнцвэржүүлж авч явах
2	Эв нэгдлийн хүчин зүйлүүдийн тархалт /давамгайлал, нийгмийн хөдөлгөөний хэлбэрийн оролцоо/		Сонголтын хүчин зүйлүүдий тархалт /давамгайлал/ мэргэшсэн оролцоо
3	Лидерүүдийн хөдөлгөөний эрх чөлөөт байдал		Лидерүүдийн хөдөлгөөний хязгаарлагдмал эрх чөлөө
4	Стратеги: Хүрээлэн буй орчны давамгайлал		Стратеги: Хүрээлэн буй орчинд дасан зохицох

Дасан зохицолтын эсрэг хүрээлэн буй орчны давамгайлал. Байгууллага бүр дотооддоо хийгээд гадаа, хүрээлэн буй орчинтойгоо олон төрлийн харилцаанд орж байдаг. Ингэж харилцах явцад нэг талаас хүрээлэн буй орчиндоо дасан зохицох, нөгөө талаас хүрээлэн байгаа орчиндоо ноёлох харилцааг үүсгэдэг. Энэхүү хоёр хандлагаар жишээлэн улс төрийн намыг авч үзье. “Улс төрийн нам сонгуулийн үед сонгогчдын саналы авахын тулд нийгэмд, хүрээлэн буй орчиндоо ноёлох байдалтайгаар үйл ажиллагаагаа явуулна. Бусад үед үйл ажиллагаа, бодлогоо нийгэмд таниулах нөгөө талаар нийгмийн зүгээс ирж байгаа сонирхол, хэрэгцээг төр оруулж улс төрийн бодлого болгох замаар нийгэмд дасан зохицох үйл ажиллагааг тогтмол явуулж байдаг”<sup>12</sup> Өмнө өгүүлсэн сонголтын хүчин зүйлсүүдийн нөлөөгөөр бий болсон бүтэц улс төрийн намыг хүрээлэн буй орчиндоо дасан зохицоход хүргэдэг бол нэгдлийн хүчин зүйлсийн үр дүнд бий болсон “төвлөрөл” бүхий бүтэц нь улс төрийн намын зохион байгуулалтыг хүрээлэн буй орчиндоо ноёлох хандлага руу түлхдэг байна. Судлаачид намын зохион байгуулалтад сонголтын хүчин зүйлс давамгайлах үед намын бүтэц, зохион байгуулалт хүрээлэн байгаа орчиндоо дасан зохицох хандлага руу, нэгдлийн хүчин зүйлс давамгайлах үед намын бүтэц зохион байгуулалт хүрээлэн буй орчиндоо ноёрхох хандлагатай болдгийг тогтоосон байдаг.

Улс төрийн нам институцжсэн байгууллага болохынхоо хувьд бүтэц зохион байгуулалтын тодорхой загварыг өөртөө бий болгон хөгжиж иржээ. Үүнийг улс төрийн намын институцжилт, бүтэц зохион байгуулалтын хөгжлийн хувьслыг хоёр онолын хүрээнд авч үзье.

Нэг. Улс төрийн намын “олигарьчлагдах онол”<sup>13</sup>. Германы эрдэмтэн Р.Михельс “Намын удирдлагын олигарьчлагдах онол”-ыг боловсруулжээ. Р.Михельс намын бүтэц зохион байгуулалт дахь удирдлагын олигарьчлагдах хандлагыг

- А. Намын хэмжээг өсгөх
- Б. Намд бюрократизмыг бий болгох
- В. Гишүүнд, дэмжигчдээс удирдлага, лидерүүд тасрах

Г. Намын удирдлага өөрсдийн засаглалыг авч үлдэх, хадгалах<sup>14</sup> гэсэн дөрвөн үзүүлэлтээр гаргасан юм. Р.Михельс “улс төрийн байгууллага болох нам нь засгийн эрх мэдэл рүү тэмүүлдэг. Эрх мэдэл ямагт консерватив байдаг”<sup>15</sup> гэсэн үндэслэлийг гаргаж “олигархийн төмөр хууль”-аа боловсруулжээ. Уг онолдоо “улс төрийн намын зохион байгуулалт бүхэн үүсэл, гарлын үе шатнаасаа эхлээд намын лидерүүд намын бүтцийн хэмжээсийг өсгөх замаар удирдлагын бюрократизмыг бий болгож өөрсдийн байр суурийг бэхжүүлж байдаг. Энэ байдал яваандаа намын дэмжигчдийг идэвхгүй байдалд оруулж намын удирдлага цөөнхийн гарт

<sup>11</sup> Angelo Panebianco. Political parties: organization and Power. Cambridge., 1988 p.20  
<sup>12</sup> J.Blondel Political Parties: A genuine case for discontent. London. 1978.p.22  
<sup>13</sup> Энэхүү онолыг Германы эрдэмтэн Р.Михельс боловсруулсан бөгөөд аливаа байгууллагад удирдах дээд хэсгийн ноёрхол цөөн шилмэл хэсгийн засаглал зайлшгүй тогтдог гэж үздэгт онолын мөн чанар оршино. Robert Michels. Political Parties: A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. USA. 1958  
<sup>14</sup> Micheals R. Political parties; A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. Glencoe. Illinois, 1958 p. 85  
<sup>15</sup> R. Michels. Political parties; A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. Glencoe. Illinois, 1958 p. 382

шилждэг”<sup>16</sup> гэж дүгнэжээ. Тэрээр зохион байгуулах чадвар эрх мэдлийг өгдөг төдийгүй зохион байгуулагдсан бүтэц өөрөө удирдагч элит гарч ирэхэд хүргэдэг гэж Р.Михельс үзсэн.

Тэрээр ардчиллыг хөгжүүлэхэд зохион байгуулалт чухал ч энэ нь хэт загварчлагдан төвлөрөхөөрөө олигархийг үүсгэж ардчиллыг унагахад хүргэдэг юм гээд нам олигархичлагдах нөхцлийг, техник, технологийн дэвшил, мэргэжлийн ур чадвар, нийгэм сэтгэл зүйн шалтгаантай тус тус холбон авч үзсэн юм. Ардчилал бэхжин хөгжихийн хэрээр удирдагч элитүүдийн нийт хүн амд хүрч ажиллах шаардлага улам бүр нэмэгдэж техник, технологийн дэвшлийг (телевиз, радио, цахим бусад хэрэгсэл) ашиглан ажиллаж удирдлагын арга барил мэдлэгтэй, мэргэжлийн байхыг шаардах болно гэдгийг онцолж байв. Харин сэтгэл зүйн шалтгаанд олон түмний санаа сэтгэлийн байдлаас үүдэлтэй удирдагчийн сэтгэл зүйг шинжилсэн байна. Нэг талаас олон түмний сэтгэл зүйн байдал нь удирдагчийн үйл ажиллагаанд шууд ба дам байдлаар нөлөөлж шийдвэр гаргах үйлдэлд хүргэдэг бол нөгөө талаасаа олон түмэн ямарваа нэг удирдлагад захирагдах сэтгэл зүйн хэрэгцээ байдагтай холбоотойг Р.Михельс тодруулж гаргасан байна. Иймд улс төрийн нам дахь удирдлагын олигархичлагдах хандлага нь удирдлагын мэргэжлсэн чадвар, хамт олон, олон түмний удирдуулах сэтгэл зүй гэсэн хоёр үндсэн хүчин зүйлтэй холбоотойг шинжилсэн явдал уг онолын гол мөн чанар юм.

**Хоёр. Улс төрийн оролцооны онол.** Энэ онолыг судлаач А. Физорно боловсруулсан. Тус онол нь нам дахь “эв санааны нэгдлийн систем”, “сонирхлын систем”-үүдийн зохион байгуулалтын ялгааг тодруулан гаргахад чиглэдэг. “Эв нэгдлийн систем нь оролцогчдын тэгш байдлыг хангах зорилт бүхий “нэгдэл”-ийн үзэлд суурилдаг бол сонирхлын систем нь оролцогчдыг олон төрлийн эрх ашиг бүхий нэгдлүүд гэж үздэг. А.Физорногийн үзсэнээр эв нэгдлийн систем нь оролцогчдын хооронд дахь эв-нэгдэлд суурилсан үйл ажиллагааны цогц байдаг бол сонирхлын систем нь оролцогчдын сонирхолд үндэслэгдсэн үйл ажиллагааны цогц”<sup>17</sup> байдаг байна.

Улс төрийн намын үүсэл гарал, зохион байгуулалтын эхний шатанд оролцогчдын оролцоо ижил байж бүтэц зохион байгуулалтын хүрээнд эв нэгдлийн систем давамгайлж байдаг байна. Харин намын төлөвшилтийн явцад намд эв нэгдэлд суурилсан бүлэг, сонирхолд суурилсан бүлгүүд зэрэгцэн оршиж цаашид намын дотоодод сонирхлын систем давамгайлах үед намын бүтцэд бюрократизм бэхжиж, оролцогчдын үйл байдлын хандлага нийгмийн хөдөлгөөний хэлбэрээс (эв нэгдлийг эрхэмлэдэг сонгогчдын систем) мэргэжлийн оролцогчдын хэлбэр рүү (сонирхлыг эрхэмлэдэг сонгогчдын систем) шилждэг зүй тогтол байдаг байна. Энэ үйл явц нь намын институцжих үйл явцын шинжийг илэрхийлж, институцжсэн байгууллага болохыг илтгэн харуулдаг.

Намын институцжилт нь намын эв нэгдлийн системээс албан ёсны зорилгыг бодит байдал болгож байгаа (онолтой загвар) болон цаашид энэхүү байдлыг сонирхлын системээр хадгалж үлдэх (байгалийн загвар) гэсэн дарааллаар явагддаг байна. Нам анх нэгдлийн хүчин зүйлээс зохион байгуулалтаа хийгээд цаашид (нийгмийн хөдөлгөөний хэлбэрийн оролцооноос хамаарч) сонгогчдын хүчин зүйл давамгайлах үед оролцогчдын үйл ажиллагаа мэргэжиж ирдэгийг өмнө дурьдсан. Харин дараа нь намын үзэл суртал илэрхий тодорхой болж (зорилгууд уялдаа холбоотой тодорхой болно) ирэхэд намд зохион байгуулалттай нуугдмал сонирхол ч давхар бий болдог аж. (зорилгуудбүдэг, үл мэдэгдэх, үгүйсгэгдмэл). Үүний дараагаар намын лидерүүдийн сонголт хийх эрх чөлөө өргөн болж ирдэг байна (тэд намын үзэл сурталыг хамгаалах, намын нийгмийн үндсийг өөрчлөх, сонгох, зохион байгуулалтын эргэн тойрон дахь нийгмийн суурь зорилгуудыг бодитой болгох). Эцэст нь хүрээлэн буй орчиндоо ноёлох байдлыг намууд өөртөө бий болгодог. Чухамхүү эндээс л улс төрийн намын зохион байгуулалтын хөгжил, төлөвшилтийн гурван үе шатыг тодруулж болох юм. 1. Үүслийн, 2. Институцжих үйл явцын, 3. Институцжсэн.

Намын зохион байгуулалтын хөгжил, төлөвшилтийн эхний үе өнөө ч илэрч байдгийг Скандиновын К.Елиасен, Л.Свэйсэнд нарын судлаачдын боловсруулсан газар нутгийн нэгдлээр болон газар нутгийн тархалтаар үүсдэг намын хөгжлийн хэв маягуудад жишээлэн авч үзье. Газар нутгийн нэгдэлд суурилсан намын үүсэл нь орон нутгийн хүрээнд холбоожсон улс төрийн бүлэглэлүүд нийгмийн зохион байгуулалтын нэгдсэн нэг бүтцэд ороход үүсдэг байна. Харин газар нутгийн тархалтад суурилсан намын үүсэл нь ахмадууд, орон нутгийн элитүүд, иргэний хөдөлгөөнүүд сайн дурын үндсэн дээр намын холбоодуудыг байгуулж, улмаар үндэсний хэмжээний намын байгууллагад нэгдэн орох үед бий болдог байна. Нам үүсэн бий болох газар нутгийн нэгдлийн хийгээд тархалтын ялгаа нь М.Дювержегийн парламентын гадна болон дотроос үүсэн бий болсон намын бүтцийн ялгаатай төсөөтэй юм. Дээрх хоёр судлаач намын үүслийн энэхүү хоёр ялгаан дээр үндэслэн нам бүрэлдэн бий болох хоёр арга замыг тодорхойлсон байна. Эхний хэлбэр нь тодорхой ашиг сонирхол, зорилго бүхий бүлэгт суурилах хэлбэрээр намын бүтэц зохион байгуулалтын үндсийг бий болгож улмаар орон нутагт мөнхүү төвөөс хамаарал бүхий бүтэц зохион байгуулалтыг үүсгэсэнээр тухайн намын улс орны хэмжээний бүтэц зохион байгуулалт бүрддэг хэлбэр байна. Өөрөөр хэлбэл намын бүтэц зохион

<sup>16</sup> Robert Michels. Political Parties: A sociological study of the oligarchical tendencies of modern democracy. USA. 1958. Pp.85

<sup>17</sup> A. Pizzorno. Introduzione allo studio della partecipazione politica. Quaderni di Sociologia, XY. pp. 252

байгуулалтыг тухайн намыг үүсгэн байгуулагчид анхлан бий болгож тэрхүү бүтэц зохион байгуулалта улс орны хэмжээнд зохион байгуулж буй арга хэлбэр юм. Намын үүсэл гарал, зохион байгуулалтын ийн загварыг судлаач К.Елиасен, Л.Свэйсэнд нар “нэгдэлд суурилсан тархалтын хэв маяг”<sup>18</sup> гэж нэрлэжээ. Ийн бүтэц зохион байгуулалт бүхий намыг дээрээс зохион байгуулагдсан буюу удирдлагын босоо тогтолцоотой нам гэж нэрлэдэг юм. Энэ төрлийн намуудын бүтэц зохион байгуулалт нь төвлөрсөн, хатуу тогтолцоотой байдаг.

Хоёр дахь арга зам нь нийгмийн тодорхой хэсгийн болон орон нутгийн хэрэгцээнээс үүдэлтэй ашиг сонирхлууд тэдгээрт суурилсан бүлгүүдийн үйл ажиллагаа улс төрийн нам, намын бүтцийг бий болгох хөрс болдогтой холбоотойгоор дээрх хоёр судлаач тайлбарласан юм. Энд нэг цаг хугацаанд өөр өөр газар нийгмийн эрэлт, хэрэгцээгээрээ ижилсэх нийгмийн бүлгүүд бодитой оршиж байдаг нь ийм арга замаар намууд үүсэн бий болох үндэс нь болж өгдөг байна. Бодитой оршин буй эдгээр эрэлт хэрэгцээ, сонирхол суурилсан нийгмийн бүлэглэлүүд улс төрийн үйл ажиллагаа, зорилго чиглэлийн хувьд зохион байгуулалтаар орсноор нам үүсэн бий болдог бөгөөд тэдгээр нам, бүлэглэлүүд үзэл баримтлал, үйл ажиллагаа, зорилго чиглэлээрээ ижилсэж ирэх үед өөр хоорондоо нэгдэх, уялдан холбогдох замаар орон нутгийн түвшнээс улс орны хэмжээний томоохон бүтэц зохион байгуулалтыг бий болгодог байна. К.Елиасен, Л.Свэйсэнд нар ийн маягаар бий болсон намуудыг “орон нутгийн тархалтад суурилсан нэгдлийн систем”<sup>19</sup> гэж нэрлэсэн.

Иймээс намд явагддаг зохион байгуулалтын үүслийн үйл явц нь нэгдэлд суурилсан бүтцээс алба ёсны зорилгыг бодит байдал болгож буй оновчтой загварын бүтэц хүртэл өрнөж цаашид нам дотор сонирхлуудаа хадгалах, өргөжүүлэхэд чиглэсэн өрсөлдөөнүүдийн хэв маягт шилжих замаар явагддаг нарийн системчлэгдсэн цогц үйл явц байдаг байна. Учир нь намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилтийн явц нь нам анх тодорхой зорилгын (засгийн эрхийг авах, түүнд нөлөөлөх гэх мэт) нэгдэлд үндэслэн зохион байгуулалтаа бий болгож цаашид намын элит, лидерүүд, жирийн гишүүдийн оролцооны ялгаа бүхий төвшингөөс хамаарч оролцогчдын үйл ажиллагаа мэргэших (professional type) хандлагтай болж тэдгээр тохирсон шатлал бүхий бүтцүүдийг бий болгож байдагтай холбоотой юм. Иймд намын бүтцийн шатлалуудыг тодруулж, тэдгээрийн үүргийн ялгаатай ба нийтлэг талуудыг гаргахын тулд дараах таван индикаторыг авч үзэх нь чухал юм.

**Нэгдүгээрт:** Парламентын бүтцээс гадуур явагддаг намын бүтэц зохион байгуулалтын төлөвшилт Намын орон нутгийн байгууллагуудын зохион байгуулалт сайжирч бүтэц бэхжин, удирдах төв байгууллага болон орон нутгийн байгууллагуудын хоорондын эргэх холбоо сайн байх явдал нь дээд байгууллагын институцжилт сайн байгааг илтгэдэг үзүүлэлт мөн. Тухайлбал, Британий Консерватив нам Лейборис намаас илүү сайн институцжсэн бөгөөд уг намд уламжлалын хүчин зүйл хүчтэйгээс гадна бүтцэд нь бюрократизм сайн бэхжсэн байдаг. Өндөр түвшинд институцжсэн намд бюрократизм, төвлөрөл их байдаг. “Бюрократизм нь төвлөрлийн үр дүнд бий болдог”<sup>20</sup> үзэгдэл юм. Харин институцжилт сул намд төвлөрөл бага, орон нутгийн байгууллагууд нь бие даасан байдалтай төвөөс нэлээд хараат бус байдаг. Ийм үед төвөөс хянах хяналт багасч, зохион байгуулалтын төвлөрөл болон түүний тархацын хэмжээ нь ялгаатай байдлаар илрэн гардаг. Тухайлбал, сул гишүүнчлэл бүхий орон нутгийн тархалтад суурилсан намуудад ийм шинж илэрхий ажиглагддаг.

**Хоёрдугаарт:** Институцжилт сайн явагдсан намын бүтэц дэхь ижил түвшний нэгжүүдийн байгуулагдах зарчим. Намуудын бүтцийн хэв маягууд тодорхой нэг зарчмын дагуу зохион байгуулагдах нь олонтаа байдаг. Тухайлбал, намууд орон нутгийн бүтцээ улсынхаа засаг захиргааны нэгжийн зарчмаар зохион байгуулах нь түгээмэл юм. Хуулиар ийм зохицуулалтыг хийсэн орнууд ч нэлээдгүй бий. Тухайлбал Монгол улс. Харин “институцжилт сайн намын анхан шатны болон орон нутгийн байгууллагууд нь сайн дурын, нэлээд олон янзын бүхий шинжийг агуулсан байдаг. Мөн төвлөрсөн аппарат сул зарим үед тохиолдлын шинжтэй байдаг. Эдгээр нь зохион байгуулалтын уялдаа холбоо болон системийн шинжийн хувьд өөр хоорондоо ялгаатай байдлаар зохион байгуулагддагтай холбоотой юм. Үр дүн нь зайлшгүй байх зохион байгуулалтад тавигдах хяналт ялгаатай байдлаар хийгдэхэд хүрдэг”<sup>21</sup> байна.

**Гуравдугаарт:** Нам яаж, хэрхэн санхүүждэг вэ? гэдэг асуудал намын институцжилтийн үйл явцад нөлөө үзүүлэгч гол индикаторын нэг мөн. Өндөр түвшинд институцжсэн намын санхүүжилт нь төрийн санхүүжилтээс гадна хандив, санхүүжилтын байнгын тогтмол эх үүсвэрүүдийг бий болгосон байдаг. Сул институцжсэн намд тогтмол орлогыг бий болгох үйл явц удаан үргэлжилдэггүй, учир нь санхүүгийн нөөцийн эх үүсвэр тодорхой бус байдагтай холбоотой. Ийм намуудад үйл ажиллагаа нь санхүүжилтын байдлаар хамаарч байнгын биш тасалдалын шинжтэй болж намын институцжих үйл явцад сөргөөр нөлөөлдөг байдаг ажиглагддаг.

<sup>18</sup> Eliassen.K, Svaasand.L. The formation of mass Politicalorganization: An analytical Framework. Scandinavian Political Studies. 1975., pp. 95-120

<sup>19</sup> Eliassen.K, Svaasand.L. The formation of mass Political organization: An analytical Framework. Scandinavian Political Studies. 1975.p. 95-120

<sup>20</sup> Angelo Panebianco. Political parties, organization and power. Cambridge., 1988.p. 58

<sup>21</sup> Angelo Panebianco. Political parties: organization and power. Cambridge., 1988.p.58

**Дөрөвдүгээрт:** Нам улс төрийн системийн бусад институциудтай харилцах харилцаа. Хүрээлэн байгаа орчин намын институцжих үйл явцад шууд нөлөөлж намын бүтэц зохион байгуулалтын ялгаатай түвшин бий болдог тухай өмнө өгүүлсэн билээ. Сайн институцжсэн нам улс төрийн системийн бусад институциудтай харилцахдаа давамгайлах байдлыг олж авахыг эрмэлздэг. Өөрөөр хэлбэл нийгэмд ноёлох байр суурьтай нам болж хувирах үйл явцаар үр дүн нь гарч ирдэг. Тухайлбал: Британий Консерватив нам. Консерватив намын бусад байгууллагуудтай харилцах харилцааны гол онцлог нь гадаад байгууллагууд энэхүү намын хувьд боловсон хүчний “дамжин өнгөрөх бүс” нь байдаг. Австрийн Социалист нам, Италийн коммунист нам, Францын коммунист нам, Германы Социаль демократ нам, Монголын МАН ийм намын жишээ юм.

Харин сул институцжсэн нам нь гадаад байгууллагуудтай шууд харилцаанд төдийлөн ороод байдаггүй, хүрээлэн буй орчиндоо давамгайлах бус харин дасан зохицох байдлаар оршиж, үйл ажиллагаагаа явуулдаг байна. Тухайлбал: Британий Хөдөлмөрийн нам. Энэ нам нь Үйлдвэрчний Эвлэл, Хоршоологчид, Эздийн холбоо зэрэг байгууллагуудаар дамжин нийгмийн бусад хэсэгт бодлогоо хүргэдэг.


**Тавдугаарт:** Намын легитимт шинэ хийгээд “жинхэнэ хүчтэй бүтэц” хоёрын хоорондын нийцтэй байдлын хэмжээ. Хэрэв энэ хоёр тохирч байвал хүчтэй институцжсэн намыг бий болгож чадна. Ийм намын зорилго нь парламентад олонхи болж парламентын лидерүүдээрээ дамжуулан ард түмэнд бодлогоо хүргэх явдал байдаг. Жишээбэл, Британий Консерватив нам, Францын Социалист нам, Бельгийн Христосын холбоо зэргийг дурьдаж болно. Харин Британий Хөдөлмөрийн намын хувьд байдал өөр. Тус намын гол зорилго нь Үйлдвэрчний эвлэлийн лидерүүдийн de facto-г авах явдал болохоос биш хэн нэгний олонд танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн байдал чухал биш юм.

Намын институцжилт сайн, бүтэц, зохион байгуулалт нь тодорхой байж чадвал нам доторх бүлэглэлүүд намын удирдлагын үйл ажиллагааг тойрон хүрээлж хүчтэй бүтцийг бий болгон намын төлөвшилтийн үйл явцад чухал нөлөө үзүүлдэг. Үүнийг дараах ойлголтуудын хүрээнд авч үзье.

**Намын хүчтэй ба сул институцжилт:** үзэл санааны хоёр хэлбэр. Институцжилт сулхан намд нэгдэл нягтрал багасан намын доторх янз бүрийн ашиг сонирхлуудын хооронд бие биендээ нөлөөлөх, давамгайллаа бий болгохын төлөөх өрсөлдөөн явагдаж, эрх, үүргийн хуваарилалт дахин бий болох үйл явц өрнөдөг. Институцжилт сайтай намд нэгтэн нягтруулах зорилгын давамгайлал (чиг баримтлалууд руу дахин хуваарилалт хийх) өсөх хандлага илүүтэй байдаг. Учир нь институцжилт сул байвал ноёлох, давамгайлах эвсэл, бүлгүүд их байдаг ба нөгөө талаар ноёлох, давамгайлах эвсэл, бүлгүүдэд хуваагдсан намд институцжих үйл явц бага явагдана гэсэн үг. Харин ноёлох давамгайлах эвсэл, бүлгүүд нэгдэн нягтарсан үед институцжилт сайн явагддаг байна. “Нам доторх бүлгүүдийн нэгдэлд суурилсан шударга өрсөлдөөн нь намд институцжих үйл явцыг өдөөж зохион байгуулалтын сайн бүтцийг бий болгодог”<sup>22</sup> тухай АНУ-ын судлаач Ж.А. Шлезингер бичсэн байдаг.

Эндээс үзэхэд улс төрийн намын институцжилтийн байдал нь намын бүтцэд нөлөөлж зохион байгуулалтын сул ба чанга бүтцийг бий болгогч хүчин зүйл болдог нь харагдаж байна. Намын дотоодод явагддаг энэхүү эсрэг тэсрэг үйл явц нь намын институцжилтийн түвшинд нам доторх бүлгүүдийн зохион байгуулалтын хоорондын харьцаанд илрэлээ олохдоо сайн институцжсэн намд (зохион байгуулалттай) зохион байгуулалтад орсон бүлгүүд бага, сул институцжсэн намд зохион байгуулалт бүхий бүлгүүд олшрох хандлагаар тусгалаа олдог байна<sup>23</sup>.

Диаграмм 2.



Өндөр түвшинд институцжсэн намд төвд тэмүүлэх хандлага хүчтэй болж энэ нь намын лидерүүдийн нэр хүндээ өсгөх, албан тушаалаа дээшлүүлэх боломжийг нээж өгдөг байна. Ийм үед намын зохистой бүтэц нь “амбицтай гишүүдийн” үйл ажиллагаан дээр суурилж тэд намын нэр хүндийг өсгөснөөр өөрсдийн эрх мэдлийг хэрэгжүүлнэ гэдгийг маш сайн ухамсарласан байдаг. Энэ бүхний үр дүн нь хүчтэй

<sup>22</sup> J.A.Schlesinger. On the concept of opportunity structure. *Ambition and Politics*. Chicago. 1966. p.75.

<sup>23</sup> Angelo Panebianco. *Political parties; organization and power*. Cambridge. 1988. p. 60

удирдагчийн удирдлага дор төвлөрсөн пирамид хэлбэрийн босоо бүтцийг бий болгодог юм. Иймээс намын институцжилтийн ийм байдлыг нарийвчлан тодруулахын тулд намын бүтцийн дотоод асуудал руу анхаарлаа хандуулах нь илүү ач холбогдолтой. Институцжилт сайн явагдсан намын дотоод бүтцийн зохион байгуулалт тэгш бус байдлын систем нь нийгмийн аль нэг хэсэг, бүлгээс үл хамаарсан, бие даасан шинжтэй байдаг байна. Харин институцжилт сул намын дотоод бүтэц дахь тэгш бус байдлын бие даасан шинж нь гадаад орчны нөлөөллөөс ихээхэн хамаарсан байдаг.

Ийнхүү дээрх үзүүлэлтүүдээр авч үзвэл институцжсэн намын дотоод бүтцийн тэгш бус байдал нь “дотоод эх үүсвэр” рүүгээ хандсан, зохион байгуулалтын онцлог нь мэргэжлийн түвшинг шаарддаг байна. Харин институцжээгүй намуудын хувьд дотоод бүтцийн тэгш бус байдал нь “гадаад эх үүсвэр” рүүгээ хандсан, зохион байгуулалтын онцлог нь гаднаас тулган хүлээлгэсэн шинжтэй байдаг байна. Үүнээс үүдэн институцжсэн улс төрийн нам түүний оролцооны хэв маяг нь илүү “мэргэшсэн” байхыг шаарддаг бол институцжээгүй намын дотоод оролцооны хэв маяг нь “иргэний” хэлбэрийг илүү хүлээн зөвшөөрсөн байдаг аж. Эндээс нам дахь оролцооны ялгаатай замууд гарч ирдэг байна.

Институцжсэн намуудад гишүүд дэмжигчдийн оролцооны зөв хэлбэр, хэв маяг төлөвшин тогтдогтоо холбоотойгоор улс төрийн лидер болох зам мөр нь маш олон шүүлтүүр шалгууруудтай байж тэрхүү шалгууруудыг даван туулж мэргэшсэн улс төрч болдог байна. Ийм тохиолдолд улс төрийн оролцоо, улс төрийн элит, лидерийн төлөвшилтийн зөв хандлага хэвшин тогтдог. Харин институцжээгүй намд байдал өөр юм. Улс төрийн элит, лидерүүд гарч ирэх үйл явц тохиолдлын шинжтэй, тэднийг сонгон шалгаруулан гаргах ирэх тогтсон механизм байдаггүй байна. Учир нь намын бүх шатны байгууллагуудын түвшинд уламжлалт сонгон шалгаруулалтын зүй тогтол маш бага, тохиолдлын улс төрчид гарч ирэх магадлал өндөр байдагтай холбоотой юм.

Ерөнхийд нь авч үзвэл институцжсэн намын зохион байгуулалтын шинж нь намын бүтцэд элитүүдийн нэгдлийн “босоо” хэлбэрийн тогтолцоог бий болгодог бол институцжээгүй намын доторх эрх мэдлийн хуваарилалт нь намын элитүүдийн дунд “хэвтээ” хэлбэрийн тогтолцоог үүсгэж жирийн гишүүд, дэмжигчид намын элит, лидерийн байр суурь, албанд шууд хүрэх боломж ихтэй байдгаараа онцлогтой байдаг. Өөрөөр хэлбэл өөрт буй нөөцүүдийг ашиглан ямар нэгэн аргаар эрх мэдэлд хүрэх боломжийг хүмүүст олгодог нь институцжээгүй намуудын гол дутагдал юм. Иймээс өндөр түвшинд институцжсэн намууд нийгмийн орчин өөрийн байр суурийг бэхжүүлж нийгмийн интеграцийн үүргээ хэрэгжүүлж байдаг бол институцжээгүй намын нийгмийн соёлын аливаа илрэлийг дагах, дасан зохицох шинжтэй байдаг юм. Иймээс ч намыг “нийгэм доторх нийгэм” гэж нэрлэх нь бий.

Аль ч намын хөгжил, хувьсал зохион байгуулалтын нэгдлийн хийгээд тархацын хэв загвараар дамжин институцждэг болох нь онолын хувьд тодорхой юм. Намын зохион байгуулалтын хөгжилд нэгдэн нийлэх хандлага давамгайлж байвал бүтцийн хүчтэй институцжилтийг бий болгодог байна. Харин намын үүсэл зохион байгуулалтын газар зүйн тархалтын хэв маяг нь намд сул институцжилтийг бий болгодог бөгөөд олон тооны сөргөлдөгч элитүүдийн хоорондын өрсөлдөөн нь тухайн намын бүтцийг харилцан нөхцөлдсөн хэвтээ маягийг тогтолцоо руу хөтөлдөг аж. Энэ үед намд хүрээлэн буй нийгэм, улс төрийн орчин, нийгмийн бүлгүүдийн нөлөөллөөс хамаарах хамаарал түүний цар хүрээ тэлдэг онцлогтой. Үүнийг доорх тохиолдлууд дээр жишээлэн тайлбарлая.

Диаграмм 3

	Нэгдэн орох үйл явц Институцжих үйл явц	Тархалтын үйл явц
Гадаад хүлээн зөвшөөрөгдөх шинж	1	2
Дотоод хүлээн зөвшөөрөгдөх шинж	3	4

Эхний тохиолдол. Энд бүх коммунист намууд тохирч байна. Коммунист намуудын гадаад легитим байдал тэдний эв нэгдэлд суурилдаг. Зохион байгуулалтын төлөвшилт нь газар нутгийн нэгдлээр дамжин

засаг захиргааны зарчмаар анхан шатны байгууллагуудаа байгуулж тэдгээрийг удирдах удирдлагын босоо тогтолцоог бэхжүүлсэн байдаг. Иймээс коммунист намуудын институцжилт сайн гэж дүгнэж болно.

*Хоёр дахь тохиолдол.* Энд Их Британий Хөдөлмөрийн нам, зарим шашны намууд, Италийн олон нийтийн намуудыг хамруулж болох юм. Эдгээр намуудын зохион байгуулалтын төлөвшилтөд газар нутгийн тархалтын шинжүүд давамгайлдаг бөгөөд бүтцэд нь бие даасан холбоодууд аяндаа бий болж гарч ирдэг онцлогтой. Учир нь нам дахь ноёлох бүлгүүдэд нөлөөлөгч гадаад хүчин зүйлүүд олон янз байдагтай холбоотой юм. Иймээс институцжих үйл явц хязгаарлагдмал байдаг.

*Гурав дахь тохиолдол.* М.Дювержегийн тодорхойлсон “парламентаас байгуулагдсан” намыг энд хамруулж болно. Намын төвөөс газар нутгийн нэгдлээр зохион байгуулалтаа хийж, парламентын гишүүд, нэр хүндтэй хүмүүс тухайн намын “толь” болж байдаг. Зохион байгуулалтын үр дүн нь хүчтэй институцжилтийг бий болгодог. Ийм намын жишээнд Их Британий Консерватив нам бусад консерватив намууд орно.

*Дөрөв дэхь тохиолдол.* Энд дотроо олон бүлгүүдийг багтаасан холбооны маягаар байгуулагдсан намууд орно. Тухайлбал. Франц дахь ажилчны интернационалист хэсэг, Италийн социалист нам, Японы социалист нам болон Германы Христийн ардчилсан холбоо зэргийг хамруулж болно. Холбоо нь хоёр ба түүнээс дээш байгууллагыг өөртөө багтаадаг, үүсэл, хөгжлийн эхлэл нь орон нутгийн тархацаар бий болсон намууд юм. Нам дотор ноёлох бүлэг, эвслүүд нэгдэл нягтралаар сул бүлгүүд аль аль нь шийдвэр гаргах түвшний байгууллагууддаа хориг тавих эрхтэй байдаг. Иймээс институцжилт сул гэсэн үг.

Эндээс бид улс төрийн намын үүсэл, зохион байгуулалтын төлөвшилтөд улс төрийн оролцоо, эс оролцоо чухал нөлөө үзүүлж институцжилтийн ялгаатай байдлыг бий болгогчийг тодорхойллоо. Үүнийг судлаач А.Панебианкогийн ангилал дээр тодруулан авч үзвэл сонирхолтой юм. А.Панебианко нам нь үүсэл, хөгжлийн үе шатаасаа бүтэц, зохион байгуулалтаа тогтоож төлөвших явцдаа дараах шилжилтүүдийг дамждаг гэж үзсэн юм.

*А.Эв нэгдлийн системээс сонирхлуудын систем рүү, бүтэцжээгүй зохион байгуулалтаас бодит зохион байгуулалт руу шилжих үйл явц. Оролцогчдын зорилго өөрөө зохион байгуулалт бий болгох сонирхол байгааг (оновчтой загварын тодорхойлолт) цаашид тэрхүү зохион байгуулалтаа авч үлдэх, хадгалах, хамгаалж бэхжүүлэх хэрэгцээнүүдээр (байгалийн загварын систем) тодорхойлогдоно.*

*Б.Үзэл санааны байдлаас зохион байгуулалтын үнэт зүйлсийг эрхэмлэн хадгалж үлдэх үзэл суртал, үзэл баримтлалын хувьсал. Энэ нь нийгмийн оролцооны хөдөлгөөний хэлбэрээс мэргэжлийн оролцооны хэлбэр болж хувирах үйл явц байдаг.*

*В. Хүрээлэн буй нийгмийн орчинд давамгайлах стратегиас хүрээлэн буй орчинд дасан зохицох хянамгай стратеги рүү шилжих шилжилт. Энэ нь намын агрегаци хийх чадварыг харуулах үзүүлэлт болдог.*

*Г. Лидерүүд хөдөлгөөний туйлын эрх чөлөөнөөс (зорилгоо хамгаалах, нийгмийн үндсээ сонгох, түүнд үндэслэн зохион байгуулалтад орох гэх мэт) сонголтын дээд зэргийн хязгаарлалтын эрх чөлөөг бий болгох хүртэл намын бүтцийн хөгжлийн хувьсал өрнөдөг<sup>24</sup> болохыг тодорхойлжээ. Энэхүү судлаачийн гаргасан намын хөгжлийн эдгээр хувьсалуудыг Германы Социаль демократ нам, Британийн Консерватив нам л ийм байдлаар хөгжсөн намд зүй ёсоор тооцогддог.*

*Төгсгөлд нь дүгнэж үзвэл намын институцжилтийг намын бүтцийн үүрэг функциудыг нийтлэг хууль, эрх зүйн хийгээд өөрийн дотоод хэм хэмжээнүүдийн хүрээнд тогтоон бэхжүүлж, нам улс төрийн системд албан ёсны байр сууриа эзлэн төлөвшиж зохион байгуулагдах үйл явцын цогц хэмээн тодорхойлж болохоор байна.*

**Abstract:** The political parties play an important role to foresee and overcome the barriers which happened during the democratic transition. The party must be the political organization, which implements the democracy. In this article presents how party organize? and party institutionalization's theories in the party studies. Here, I made a conclusion that it is related to subordinating organization pattern of political parties in certain places.

<sup>24</sup> Angelo Panebianco. Political parties: organization and power. Cambridge., 1988 p. 164-165

**НОМ ЗҮЙ:**

1. Г.Алмоц, Д.Пауэл нар. Харьцуулсан улс төр. Онолын хүрээ. Орч. Ё.Довчин. УБ., 2005
2. Азийн барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УТБА.УБ., 2008
3. Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. ННФ.УБ.,2006
4. Д.Болд-Эрдэнэ. Монгол дахь нам, намын систем.УБ., 2001 он
5. М.Дюверже. Улс төрийн байгууламж. Үндсэн хуулийн эрх зүй. УБ.,2007
6. Р.Даль. Ардчиллын тухай. Орч.Д.Ганхуяг. УБ.,1998
7. С.Зульфикар. Британий төрийн тогтолцоо. УБ.,2003
8. А.Лийнхарт. Ардчиллын хэв загвар. Гучин зургаан орны төр засгийн хэлбэр ба илрэл. Орч.Д.Ганбат. УБ.,2008
9. О.Машбат. Бонноос Вестминстрийн зүг. УБ., 2007
10. Улс төрийн намууд. Лавлах. УБ., 1986
11. Й.А.Шумпетер. Капитализм,Социализм,Ардчилал. Орч.Т.Түвшин.УБ.,2006
12. Д.Цэрэндорж нар. Намын зохион байгуулалт судлах аргын зөвлөмж. УБ., 1984
13. А.Юндэндорж. Нийгэм иргэнлэг ардчилсан хэв шинжийг олоход төрийн институтын гүйцэтгэх үүрэг. УБ., 2001
14. М.Я.Острогорский. Демократия и политические партии. М.,1997
15. Основы теории политических партий. Ред.С.Е.Заславский.М.,2007
16. Ю.Юдин. Политические партии и право в современном государстве. М.,1998
17. Arjen Boen. Crafting Public Institutions. Leadership in Two Prison Systems.USA.1984
18. Bentley.A. The process of Government: A Study of Social Pressures. Cambridge.1967
19. Christopher W.Allinson. Bureaucratic Personality and Organisation Structure.GB.,1984
20. L. Diamond, R.Gunther. Political Parties and Democracy. London.,2001
21. R S.Katz, P Mair. How Party Organize. Change and Adaptation in Party Organizations in Western Democracies.London., 1994
22. K R.Luther. Party Elites in Divided Societies. Political parties in Consociational Democracy.USA., 1989
23. Michels R. Political Parties.A Sociological Study of the Oligarchical Tendencies of Modern Democracy. USA., 1958
24. Party Organizations. A Data Handbook. Edited by R S.Katz, P Mair. London.,1995
25. A. Panebianco. Political parties: Organization and Power.Cambridge., 1988
26. Д.Болд-Эрдэнэ. Олон намын тогтолцооны эрх зүйн үндэс. Шинэ толь.№ 3.УБ., 1994
27. Д.Болд-Эрдэнэ. Монгол дахь олон намын тогтолцоо: үүсэл, төлөвшил, сургамж, хөгжлийн хандлага. Бодрол бясалгал. № УБ.,1992
28. С.Мөнхбат. Намын санхүүжилтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудалд. Альтернатив сэтгүүл. №1. УБ., 2003
29. С.Мөнхбат. Улс төрийн намын бүтэц зохион байгуулалтын эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. Политологи сэтгүүл. 2.УБ., 2005 он
30. С.Мөнхбат. Орчин үеийн намын хөгжлийн хандлага: Монголын намуудад тулгарч буй сорилтууд. Политологи сэтгүүл. 4.УБ., 2008
31. Richard S. Katz and Peter Mair. Cahnging Models of Party Organization and Party Democracy. The Emergence of the Cartel Party. European Politics Journal. Vol.1.pp.5-28.1995
32. Richard S. Katz and Peter Mair. Cadre, Catch-All or Cartel?. European Politics Journal.Vol.2.No 4. pp.525-534.,1996